

# НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

## БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

1921 оны Монгол Ардын Хувьсгал Монгол орны тусгаар тогтнолыг тунхаглан, ард түмнийг гэгээрүүлэх, шинэ үеийн бичиг, соёлд суралцуулах эрдэм оюуны эх ундаргыг нээсэн түүхэн цаг үеэс эхлэн олон ардыг соён гэгээрүүлэх байгууллага нэн шаардлагатай болсон байна. Энэ зорилгоор : Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны 1923 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн шийдвэрээр Улаанбаатар хотод “Ардын Цэнгэлдэх хүрээлэн”-г анхлан байгуулжээ.

1924 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хуралдсан БНМАУ-ын Анхдугаар Их Хурлын 04 дүгээр хуралдаанаас Улаанбаатар хотын түр захиргааг ардчилсан сонгуулиар анх удаа сонгон байгуулж, тус хурлаас хотын захиргааны дагаж мөрдөх дүрмийг баталсан байна..Энэ дүрмээр хотын захиргаа нь үйл ажиллагааны чиглэлээр 6 хэлтэстэй байхаар тогтоосон боловч энэ бүтцэд Соёлын хэлтэс бие даасан байдлаар байгуулагдаагүй байна.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага хурлын 1937 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 04 дүгээр тогтоол, Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 02 дугаар хурлаас хотын захиргааг өөрчлөн нийслэл Улаанбаатар хотыг захирах яам болгож, Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 12 дугаар хурлаар Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг шинэчлэн баталж, дүрмийн 04 дүгээр бүлэгт тус яамны зохион байгуулалт, бүтцийг батлахдаа Ардын соёл, боловсролын хэлтэс байхаар тогтоож, уг хэлтэс урлагийн төлөөлөгч гэсэн орон тоог баталснаар өнөөгийн Соёл, урлагийн газрын анхны тулгын чулуу тавигдсан юм.

Сайд нарын Зөвлөлийн 1958 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 36 дугаар тогтоолоор Соёлын хэлтсийг байгуулж, Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 601 дүгээр тогтоолоор Соёлын хэлтсийг татан буулгажээ.

Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор хотын захиргаанд Соёлын хэлтсийг дахин байгуулж, соёлын хоёр мэргэжилтэнтэйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн Газрын 1996 оны 263 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг Даргын 1997 оны 01 дүгээр сарын Б/18 дугаар, 8 орон тоотой Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёлын газар, Нийслэлийн Засаг Даргын 2005 оны 15 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагын газар болжээ.

Нийслэлийн Засаг Даргын 2009 оны 14 дүгээр, 2009 оны 11 дүгээр сарын 12-ны 608 дугаар захирамжаар 8 орон тоотой, Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын 2011 оны 516 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоо 12 хүртэл, 2013 оны 03 дугаар сарын 19-ний А/314 дүгээр захирамжаар бүтэц орон тоог 20 хүнтэйгээр баталсан.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагын газар нь 2013 оноос Захиргаа удирдлагын хэлтэс , Урлаг уран сайхны хэлтэс нэгжтэй болж нийт 12 орон тоотой ажиллаж байна.

### **Соёлын газрын үндсэн үүрэг нь:**

Нийслэлийн хүн амын өсөн нэмэгдэж буй соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, уран сайхны боловсролыг нь дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлж, үндэсний уламжлалт соёлыг өвлүүлэн эзэмшүүлэх, зах зээлийн нийгэмдэх соёл, урлагийн төлбөрт үйлчилгээг шинээр нэвтрүүлэн, соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулж байх зорилго, чиглэл бүхий үүргийг хүлээн ажиллах болжээ.

Энэхүү зорилго, чиглэлийн хүрээнд Улаанбаатар хотын Соёлын газар нь бүтэц, зохион байгуулалтын хувьд газрын дарга, кино урлаг, соёлын төлбөрт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, нийтийг хамарсан урлаг уран сайхан, номын сан, соёлын төв хариуцсан мэргэжилтэн, түүх соёлын дурсгалт зүйл, музей хариуцсан мэргэжилтэн, нарийн бичиг, бичиг хэргийн эрхлэгчийн 5 орон тоотой ажиллаж байжээ. хэлтэс нэгжтэй болж нийт 12 орон тоотой ажиллаж байна.

#### **Соёл, урлагийн газрын эрхэм зорилго нь:**

Нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, гоо зүй болон уран сайхны боловсрол, мэдрэмжийг дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшүүлэх, соёлын олон талт үйл ажилагааг жигд чанартай зохион явуулахад оршино.

#### **Соёл, урлагийн газрын үндсэн үүрэг, үйл ажиллагаа нь:**

Соёл, урлагийн талаархи зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн дээд түвшинд удирдан зохион байгуулах, нийслэлийн ИТХ, Засаг даргыг соёл урлагийн мэргэжлийн өндөр түвшинд цаг үеэ олсон эцсийн шатны бодлого, зөвлөмжөөр шуурхай ханган, нийслэлийн хүн амын соёлын түвшин болон хариуцсан салбарынхаа ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэн ажиллахад чиглэнэ.

#### **Тус газар одоогоор ажиллаж байгаа орон тоо :**

- Газрын дарга

#### **Захиргаа удирдлагын хэлтэс:**

- Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
- Хүний нөөц, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан
- Мэдээлэл технологи, соёлын төлбөрт үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Гадаад харилцаа, олон нийт, хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Төсөв, статистик, нягтлан бодох бүртгэл хариуцсан мэргэжилтэн
- Ерөнхий нягтлан бодогч

#### **Урлаг уран сайхны хэлтэс:**

- Урлаг уран сайхны хэлтсийн дарга
- Нийтийн Соёл, чөлөөт цагийн арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн
- Соёлын биет бус өв, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн

#### **Соёл, урлагийн газрын харъяа байгууллагууд:**

- Нийслэлийн Соёлын Төв Өргөө
- Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын Номын сан. /Салбар номын сангууд: Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд байрладаг./
- Улаанбаатар хотын Музей.
- Дүүргүүдийн Соёлын ордон . /Багахангай, Багануур, Баянзүрх, Налайх, Хан-Уул, Сүхбаатар, Сонгино- Хайрхан дүүргийн Жаргалант тосгоны соёлын төв, хороодын соёлын танхим/
- Кино театрууд. / Өргөө, Соёмбо, Тэнгис, мини кино театрууд г.м/

#### **Соёлын хэлтэс буюу Соёл, урлагийн газар байгуулагдсанаас хойш тус байгууллагын даргаар ажиллаж байсан үе үеийн удирдлагууд :**

- |              |              |
|--------------|--------------|
| ➤ Осор       | 1958 он      |
| ➤ Очирбат    | 1958-1959 он |
| ➤ Дамба      | 1959-1966 он |
| ➤ Цэндээжээ  | 1966-1969 он |
| ➤ Дашломбо   | 1969-1972 он |
| ➤ Ичинхорлоо | 1972-1974 он |

➤ Шагдар	1974-1980 он
➤ Д.Дунхүү	1980-1981 он
➤ Цэнд	1981-1983 он
➤ С.Мөнхөө	1983-1988 он
➤ Б.Бизъяа	1988-1992 он
➤ Г.Нямсамбуу	1992-2002 он
➤ Ц.Энхбат	2002-2005 он
➤ Ц.Пүрэвхүү	2005-2013 он
➤ Б.Батцэнгэл	2013 оноос одоог хүртэл ажиллаж байна.

**Соёл, урлагийн газрын зохион байгуулдаг томоохон уламжлалт арга хэмжээнүүд:**

- Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээнүүд
- Шинэ жилийн ёслолын арга хэмжээ
- Хүүхдийн баярын соёлын арга хэмжээ
- Нийслэлийн өдөрт зориулсан соёл, урлагийн цогцолбор арга хэмжээ
- Ардын урлагийн наадам
- “Улаанбаатар” кино наадам
- Хүүхдийн найрал дууны уралдаан
- БНСУ-ын Намъянжу хот, Улаанбаатар хотын хамтын ажиллагааны хүрээнд ардын урлагийн хамтлаг, уран бүтээлчдийн солилцоо
- БНХАУ-ын Хөх хотод зохиогддог Олон улсын ардын урлагийн наадам
- БНХАУ-ын Манжуур хотын захиргаатай хамтран зохион байгуулдаг “Олон улсын гоо бүсгүй шалгаруулах уралдаан”
- Морин хуур, уртын дууны наадмууд зэрэг соёл, урлагийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

**Соёл, урлагийн газраас зохион байгуулсан томоохон арга хэмжээнүүд:**

- Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Ардын хувьсгалын 85 жилийн ойн баяр наадмын хүндэтгэлийн арга хэмжээний 800 уртын дууч, 800 морин хуурчдын тоглолт
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ
- Москва хотын соёлын өдрүүд Улаанбаатар хотод
- Сөүл хотын соёлын өдрүүд Улаанбаатар хотод
- Улаанбаатар хотын соёлын өдрүүд Москва, Сөүл, Улаан-Үүд хотуудад
- Будапешт хотын соёлын өдрүүд Улаанбаатар хотод
- Улаанбаатар хотын соёлын өдрүүдийг Турк улсын Анкара хотод
- Австрали улсын кино өдрүүдийг Улаанбаатар хотод
- Нийслэл Улаанбаатар хот байгуулагдсаны 355-374 жилийн ойн өдрүүдийг тус тус зохион байгуулсан юм.
- Соёл, урлагийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулах, соёлын өдрүүд, уралдаан, наадам, урлагийн тоглолт зэргийг жил бүр зохион байгуулан, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэн, үр дүнг дээшлүүлэн ажиллаж бана Үүнд:

БНСУ-ын Сөүл, Намъянжу, БНХАУ-ын Хөх хот, ОХУ-ын Улан-Үд хотуудын соёл урлагийн газартай харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулж хамтран ажилласан. БНСУ-ын Намъянжу хотын Монгол тосгонд урлагийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулан гэрээ хийж уран бүтээлчийг ажиллуулан хамтран ажиллаж байна.

Монгол үндэстний загварт цамын бүжгийн хувцас хэрэглэлийг сонгож НЗДТГ-аас 10 гаруй сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн БНСУ-ын Намъянжу хотын Монгол тосгонд хүлээлгэн өгсөн.

БНСУ-ын Сөүл хотод жил бүр зохион байгуулагддаг “Hi Seoul-“ олон улсын наадам, ОХУ-ын Иркутск хотын 350 жилийн ой, Турк улсын Анкара хот, БНСУ-ын Сөүл хотын Сунпа дүүргийн Хансан Пэнгжэ урлагийн наадамд Улаанбаатар чуулгын урлагийн тоглолт, бусад мэргэжлийн байгууллагын уран бүтээлчдийн тоглолтыг айлчлан тоглууллаа.

БНХАУ-ын Манжуур хотын хамтын ажиллагааны хүрээнд 5-р сард Бээжин хотод зохион байгуулсан Олон улсын Соёлын зөвлөлгөөнд мэргэжилтэн, соёл судлаачдын төлөөлөгчдийг оролцуулав.

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны наадам”-ыг 19 дэх удаагийн уралдаанд “Улаан-Үд” хотын Хөгжмийн тусгай сургуулийн найрал дууны хамтлагийг урилгаар оролцууллаа.

БНХАУ-ын Хөх хотод зохион байгуулагдсан “Улаанбаатар хотын эдийн засаг, хамтын ажиллагааны өдөр”-т Улаанбаатар чуулгын уран бүтээлчид, ардын урлагийн “Домог”, рок попын “Хурд” хамтлагууд бие даасан болон хүндэтгэлийн тоглолтыг Хөх хотын урлагийн театрт хийв. Улаанбаатар хотын музей, зураачид гэрэл зураг, уран зургийн үзэсгэлэнг гаргаж, үндэсний үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж энэ үйл ажиллагаанд 160 гаруй уран бүтээлчид, бизнесийн төлөөлөгчид оролцлоо.

БНХАУ-ын “Жао Жун хатны баяр” Олон улсын урлагийн наадамд Улаанбаатар чуулгын уран бүтээлчдийг оролцуулав.

Итали улсын “Милан хотын өдөр”-ийг Улаанбаатар хотноо НЗДТГ-ын ГХХАХ-тэй хамтран зохион байгуулж, Итали улсын кино өдрүүдийг Тэнгис, Өргөө кино театрт хийж, кинонуудын танилцуулгыг орчуулж, иргэдэд үзүүллээ.

### **Хөмрөгийн баримтын түүх**

Тус газар нь “Нийслэлийн Архивын газар”-тай анх 2005 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан эрдэм шинжилгээ, техник боловсруулалтыг гэрээний дагуу байгууллага дээр хадгалах хугацаа дууссан 1979-2004 оны нийт 153 хадгаламжийн нэгжийг хүлээлгэн өгсөн байна.

Баримтад ЭШТБ хийгдсний дагуу байнга хадгалах 1990-2004 оны 95 ХН-ээр төрийн архивт 173 дугаар хөмрөг үүсгэж, түр хадгалах 1997-2004 оны 78 хадгаламжийн нэгжийг бүртгэлд оруулж өгсөн байна.

Тус байгууллагын архивын ажилтнаар 1999-2004 онд Д.Энхчимэг, 2005-2007 онд С.Насанбат, 2007-2012 онд М.Баасандорж нар ажиллаж байсан бөгөөд архивын баримтыг заавар журмын дагуу үдэж хавтаслан байнга, түр хадгалах баримтуудыг тус тусад нь ангилан төрөлжүүлж эмх цэгцтэй хадгалж ирсэн байна.

Нийслэлийн Архивын газрын нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу Нийслэлийн Соёл урлагийн газрын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан Л.Баяртуяа нь Нийслэлийн Архивын газрын Төлөвлөлт арга зүйн хэлсийн зааварлагч арга зүйч Н.Цацралтуяагаас өгсөн мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөөний дагуу байгууллагын архивт хадгалагдаж буй 1979-2013 оны баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг ажлыг гүйцэтгэв.

Мөн архивын мэргэжилтнүүдийн зааврын дагуу данс бүртгэлээ төрийн архивын 173 дугаар хөмрөгт хадгалагдаж буй Нийслэлийн Соёлын газрын байнга хадгалах 1990-2004 оны 95 хадгаламжийн нэгж бүхий 1 дүгээр дансны үргэлжлэлээр оруулахаар шийдвэрлэн байнгын дансаа 1999-2009, 2010-2013 он гэж 2 салгаж оруулан 1999-2009 оны байнга хадгалах баримтыг төрийн архивын сан хөмрөгт хүлээлгэн өгч 2010-2013 оны баримтыг байгууллага дээр түр үлдээн түр, 70 жил хадгалах баримтуудыг тус тусад нь ангилан төрөлжүүлж архивын зааврын дагуу тавиурт өрж байрлуулав.

### **Байгууллагын архивт хадгалагдаж байгаа баримтын бүрдлийн хувьд:**

- **Байнгын бүртгэлд:** Дээд газрын тогтоол, захирамж, газрын даргын тушаал, хурлын тэмдэглэл, Нийгэм эдийн засгийн зорилт, Засгийн газрын, Нийслэлийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ, биелэлт, газар, хэлтсийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, хөтөлбөрийн хэрэгжилт, соёл урлагийн олон талын үйл ажиллагаатай холбогдолтой баримтуудаас бүрдэж байна.
- **70 жилд:** Даргын боловсон хүчний тушаал, цалингийн хүснэгт, цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.
- **Түрд:** Дээд газраас ирсэн цаг үеийн шинж чанартай тогтоол, шийдвэр, ирсэн, явуулсан бичиг, бүртгэлийн дэвтрүүд, ажиллагсдын үр дүнгийн гэрээ, биелэлт, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан, мэдээ, хөтөлбөрийн улирал, хагас жилийн хэрэгжилт, шуурхайн мэдээ, журнал, харилцах, мөнгөн хөрөнгийн баримт, кассын баримт, нягтлан бодох бүртгэлийн баримт, ажилчдын үр дүнгийн гэрээ, цагийн бүртгэл, харъяа байгууллагын сар улирлын төлөвлөгөө, тайлан зэрэг баримтуудаас бүрдэж байна.
- **Тусгай төрөлд:** Тус газраас зохион байгуулдаг хүүхдийн найрал дууны дүрс бичлэг, бусад соёлын үйл ажиллагаа, түүх дурсгалтай холбоотой гэрэл зураг, цомог зэрэг баримтуудаас бүрдэж байна.

### **Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлын явцад дараах ажлыг хийж гүйцэтгэх явцад:**

- Газрын даргын тушаалыг 2008-2013 оны үйл ажиллагааны болон боловсон хүчний асуудлаар 2 ангилан он, сар, өдрийн дараалалд оруулж, хуудас дугаарлах, үдэж хавтаслах, нуруу цаас наах, нүүр бичилт хийх зэрэг техник боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Дээд газраас ирсэн тогтоол, захирамж, ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг ач холбогдол, хадгалах хугацаагаар нь байнга, түр болгож ангилан, байнга хадгалагдах ирсэн, явуулсан бичгийг 2008 оноос эхлэн байнга, түр хадгалах хугацаагаар ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлж авсан.
- Үндэсний болон дэд хөтөлбөрүүдээс тухайн жилд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, холбогдох баримтуудыг байнга салган авч, сар, улирал, хагас жилийн төлөвлөгөө, тайлан мэдээг түрд үлдээв.
- Түрийн бүртгэлээс 2005-2009 оны цалин, ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 70 жилд авч, 70 жилд хадгалах хэргийг бүрдүүлэн техник боловсруулалтын ажлыг хийсэн. 2005-2009 оны касс харилцахын баримтаас цалин, нийгмийн даатгал, жилийн эцсийн тайлан, мэдээг түүсэн.
- 2010-2013 оны Санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан зэрэг нь санхүүгийн баримтад хамт үдэгдсэн, санхүүгийн баримтын шалгалтад ороогүй, хадгалах хугацаа нь дуусаагүй тул задлалгүй түрийн бүртгэлд нь үлдээв.
- 2008-2009 оны байгууллагад ирсэн бичиг явуулсан бичгийн байнга, түр хадгалах гэж ангилсан.
- 1997- 2004 оны нийгмийн даатгалын тайлангаас төсвийн гүйцэтгэлийн мэдээг салгаж байнга хадгалах нэгжид авсан.
- 1995-2005 оны өргөдөл, гомдол, байгууллагын сар, улирлын мэдээ, төлөвлөгөө, тайлан, шуурхайн мэдээ, ажиллагсдын үр дүнгийн гэрээ, ирсэн явуулан бичиг, ирсэн явсан бичгийн бүртгэлийн дэвтэр, цагийн бүртгэл, касс харилцах, харъяа байгууллагад хяналт хяналт шалгалт хийсэн баримт бичиг зэргийг нягтлан шалгаж

хадгалах хугацаа дууссан, түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 14 хэргийн 44 ХН-д устгах хэргийн акт үйлдсэн.

**Эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлын үр дүнд:**

- 1999-2009 оны 123 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2010-2013 оны 74 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 1999-2013 оны 127 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1979-2013 оны 36 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 2001-2013 оны 39 хадгаламжийн нэгж бүхий тусгай төрлийн дүрс бичлэг,
- 2008-2011 оны 4 CD бүхий гэрэл зургийн баримтын бүртгэл,
- 2005-2012 оны 192 зураг бүхий гэрэл зургийн цомгийн 1 бүртгэл,
- 1995-2007 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 12 нэр төрлийн 40 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.

Дээрх данс, бүртгэл, актыг Нийслэлийн Соёл урлагийн газрын дэргэдэх ББНШК-ийн 2014 оны 05 дугаар сарын 22-ны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн Нийслэлийн Архивын газрын дэргэдэх ББНШАЗК-ийн хурлаар оруулахаар шийдвэрлэв.